



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2018 оны 3 дугаар сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 3 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26%-иар буюу 537 сая ам.доллараар өсч 2,613 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 14%-иар буюу 183 сая ам.доллараар, импорт 46%-иар буюу 354 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 172 сая ам.доллараар буурч 352 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 3 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	1,558	2,076	2,613	518	33%	537	26%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	959	1,300	1,482	341	36%	183	14%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	599	776	1,130	177	30%	354	46%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	360	524	352	164	46%	(172)	-33%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2018 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 125 сая ам.доллараар буурч 403 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 63% буюу 1,642 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 379 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 57%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 15%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7%-иар өссөн бол өмнөх сараас 1%-иар буурч 1.748-д хүрлээ. Тайлант сард импортын хэмжээ өссөнөөс голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас мууджээ.

**Экспорт** 2018 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14%-иар буюу 183 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт болон аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг харгалзан 13.2, 0.5 нэгж хувиар өсөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 0.2 нэгж хувиар буурсан байна.

**Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>1. Уул уурхай</b>		<b>843</b>	<b>88%</b>	<b>1,202</b>	<b>92%</b>		<b>1,374</b>	<b>93%</b>		<b>359</b>	<b>43%</b>	<b>37%</b>	<b>172</b>	<b>14%</b>	<b>13.2%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	413	482	50%	366	30	29%	338	463	31%	(101)	-21%	-11%	82	22%	6%
1.2. Чулуун нүүрс	3,252	99	10%	8,016	538	41%	6,613	509	34%	440	444%	46%	(29)	-5%	-2%
1.3. Боловсруулаагүй нефть	2,221	73	8%	1,839	93	7%	1,631	101	7%	20	27%	2%	8	8%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	988	29	3%	1,106	70	5%	1,441	64	4%	41	142%	4%	(6)	-9%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /kg/	2,902	111	12%	1,111	44	3%	2,950	124	8%	(68)	-61%	-7%	81	184%	6%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	23	23	2%	27	40	3%	33	60	4%	18	79%	2%	20	49%	2%
1.7. Жонш, лейцит, нефелинт	53	12	1%	53	12	1%	78	25	2%	0	2%	0%	13	106%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	6	1%	2	9	1%	1	10	1%	2	41%	0%	1	17%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	2	0%	0	1	0%	0	1	0%	(1)	-59%	0%	(0)	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	17	6	1%	0	-	0%	0	0	0%	(6)	-100%	-1%	0	0%	0%
1.11. Бусад	19	1	0%	134	15	1%	164	16	1%	14	2290%	1%	2	10%	0%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>67</b>	<b>35</b>	<b>4%</b>	<b>121</b>	<b>36</b>	<b>3%</b>	<b>123</b>	<b>42</b>	<b>3%</b>	<b>1</b>	<b>2%</b>	<b>0%</b>	<b>6</b>	<b>16%</b>	<b>0.4%</b>
2.1. Амьд мал, малын мах	1	3	0%	3	5	0%	6	14	1%	3	102%	0%	9	170%	1%
2.2. Арьс, шир	61	12	1%	115	10	1%	112	6	0%	(2)	-17%	0%	(4)	-40%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	1	0%	0	1	0%	0	2	0%	(0)	-6%	0%	1	0%	0%
2.4. Ноолуур	1	14	1%	1	16	1%	2	17	1%	2	13%	0%	1	5%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	5	0%	2	3	0%	2	3	0%	(2)	-36%	0%	(0)	-1%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	497%	0%	(0)	-12%	0%
<b>3. Газар тариалан</b>	<b>47</b>	<b>7</b>	<b>1%</b>	<b>17</b>	<b>2</b>	<b>0%</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>(6)</b>	<b>-78%</b>	<b>-1%</b>	<b>(1)</b>	<b>-47%</b>	<b>-0.1%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>65</b>	<b>73</b>	<b>8%</b>	<b>117</b>	<b>60</b>	<b>5%</b>	<b>51</b>	<b>66</b>	<b>4%</b>	<b>(13)</b>	<b>-18%</b>	<b>-1%</b>	<b>6</b>	<b>10%</b>	<b>0.5%</b>
4.1. Хүнс	2	12	1%	5	19	1%	6	20	1%	7	62%	1%	1	7%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	2	0%	0	3	0%	0	4	0%	2	89%	0%	1	28%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	3	0%	0	3	0%	1	3	0%	(0)	-7%	0%	1	23%	0%
4.4. Уул уурхай	5	16	2%	7	25	2%	8	27	2%	9	60%	1%	2	10%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-69%	0%	0	255%	0%
4.6. Машины механик, тоног төхөөрөмж, эд анги	0	40	4%	0	9	1%	1	9	1%	(31)	-78%	-3%	0	4%	0%
4.7. Бусад	57	1	0%	104	1	0%	35	1	0%	0	2%	0%	0	13%	0%
<b>5. Бусад</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-40%</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>33%</b>	<b>0.0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>959</b>		<b>1,300</b>			<b>1,482</b>			<b>341</b>	<b>36%</b>		<b>183</b>	<b>14%</b>	

%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 3 дугаар сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	(48.6)	%	(220.1)	%	(172)	(14%)
<b>1. Уул уурхай</b>	<b>(48.6)</b>		<b>220.1</b>		<b>172</b>	<b>14%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(38.5)	-47%	120.8	147%	82.3	22%
1.2. Чулуун нүүрс	(108.1)	372%	79.1	-272%	(29)	-5%
1.3. Боловсруулаагүй нефть	(12.9)	-163%	20.8	263%	8	8%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	14.8	-240%	(21.0)	340%	(6.2)	-9%
1.5. Мөнгөжөөгүй алт /kg/	77.5	96%	3.1	4%	80.6	184%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	10.0	50%	9.8	50%	19.9	49%
1.7. Жонш, лейцит, нефелинт	8.1	63%	4.8	37%	12.9	106%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(2.3)	-155%	3.8	255%	1.5	17%
1.11. Бусад	3.1	(1.5)	-98%	1.6	10%	
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>15.3</b>		<b>(9.2)</b>		<b>5.6</b>	<b>16%</b>
2.1. Амьд мал, малын мах	7.5	87%	1.2	13%	8.7	170%
2.2. Арьс, шир	(0.1)	3%	(4.0)	97%	(4.1)	-40%
2.4. Ноолуур	7.5	969%	(6.8)	-869%	0.8	5%
<b>3. Газар тариалан</b>	<b>(8.1)</b>	<b>1081%</b>	<b>7.4</b>	<b>-981%</b>	<b>(0.8)</b>	<b>-47%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>10.0</b>	<b>165%</b>	<b>(4.0)</b>	<b>-65%</b>	<b>6.1</b>	<b>10%</b>
<b>5. Бусад</b>	<b>(0.0)</b>	<b>-65%</b>	<b>0.1</b>	<b>162%</b>	<b>0.1</b>	<b>33%</b>
<b>Нийт дүн</b>	<b>(31)</b>		<b>214</b>		<b>183</b>	<b>14%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2018 оны эхний 3 сард экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 31 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 214 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ буурснаас шалтгаалж 147 сая ам.доллараар буурсан хэдий ч үнэ өссөнөөс шалтгаалж 200 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс голлон шалтгаалж 6 сая ам.доллараар өссөн байна.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 3 дугаар сард 1,327 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар өссөн, өнгөрсөн сараас 0.4%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,799; 70 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 17%-иар өсч, төмрийн хүдэр 20%-иар буурсан бол өнгөрсөн сараас зэс, төмрийн хүдэр харгалзан 3%, 9%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 3 дугаар сард 77 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17%-иар өссөн, өмнөх сараас 11%-иар буурсан байна.

**Импорт** 2018 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 46%-иар буюу 354 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 17 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 10 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүн болон хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт тус бүр 9 нэгж хувийг тайлбарлаж байна.

**Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>210</b>	<b>35%</b>		<b>255</b>	<b>33%</b>		<b>322</b>	<b>28%</b>	<b>45</b>	<b>21%</b>	<b>7%</b>	<b>67</b>	<b>26%</b>	<b>9%</b>
Түргэн эдэлгээтэй	162	119	20%	197	143	18%	205	175	15%	25	21%	4%	31	22%	4%
Хүнс	79	82	14%	72	96	12%	97	123	11%	14	17%	2%	27	28%	3%
Эм, тариа	0	15	2%	1	22	3%	0	22	2%	7	47%	1%	1	3%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	82	22	4%	124	26	3%	107	30	3%	4	18%	1%	4	16%	1%
Удаан эдэлгээтэй	28	92	15%	53	111	14%	30	147	13%	20	22%	3%	36	32%	5%
Гутал, хувцас, цүнх	14	11	2%	15	12	2%	11	15	1%	1	14%	0%	3	27%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	3	19	3%	24	21	3%	9	24	2%	1	7%	0%	3	14%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	48	8%	0	66	9%	0	91	8%	18	38%	3%	25	38%	3%
Бусад удаан эдэлгээтэй бараа	11	14	2%	14	12	2%	10	17	2%	(1)	-10%	0%	5	39%	1%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>256</b>	<b>187</b>	<b>31%</b>	<b>219</b>	<b>265</b>	<b>34%</b>	<b>377</b>	<b>400</b>	<b>35%</b>	<b>78</b>	<b>42%</b>	<b>13%</b>	<b>135</b>	<b>51%</b>	<b>17%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, ад анги	3	110	18%	6	193	25%	4	256	23%	82	74%	14%	63	33%	8%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, ад анги	0	19	3%	0	34	4%	0	75	7%	14	74%	2%	41	123%	5%
Машин механик, тоног төхөөрөмж, ад анги	3	91	15%	6	159	20%	4	181	16%	68	75%	11%	22	14%	3%
Барилгын материал	77	38	6%	58	45	6%	93	93	8%	7	18%	1%	48	105%	6%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	6	38	6%	7	27	3%	7	51	5%	(11)	-29%	-2%	24	90%	3%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>187</b>	<b>113</b>	<b>19%</b>	<b>268</b>	<b>96</b>	<b>12%</b>	<b>345</b>	<b>176</b>	<b>16%</b>	<b>(17)</b>	<b>-15%</b>	<b>-3%</b>	<b>80</b>	<b>83%</b>	<b>10%</b>
Хүнсний орц	80	18	3%	9	3	0%	126	39	3%	(14)	-81%	-2%	36	1042%	5%
Химийн бүтээгдэхүүн	20	14	2%	32	19	2%	43	24	2%	5	33%	1%	6	31%	1%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	4	4	1%	7	5	1%	13	5	0%	1	28%	0%	1	15%	0%
Цахилгаан эрчим хүч	0	32	5%	0	24	3%	0	36	3%	(8)	-25%	-1%	12	51%	2%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	0	0	0%	0	0	0%	(1)	-88%	0%	0	42%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	151	45	8%	171	45	6%	193	71	6%	0	0%	0%	25	55%	3%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>187</b>	<b>88</b>	<b>15%</b>	<b>268</b>	<b>159</b>	<b>20%</b>	<b>345</b>	<b>231</b>	<b>20%</b>	<b>71</b>	<b>81%</b>	<b>12%</b>	<b>72</b>	<b>45%</b>	<b>9%</b>
Дизель түлш	84	35	6%	145	80	10%	207	134	12%	44	126%	7%	54	68%	7%
АИ-92, АИ-95	78	36	6%	86	53	7%	84	57	5%	17	48%	3%	4	8%	1%
А-80 болон бусад	25	17	3%	37	27	3%	54	40	4%	10	57%	2%	13	50%	2%
Бусад	1	1	0%	4	2	0%	52	2	0%	1	158%	0%	0	14%	0%
<b>Нийт дүн</b>		<b>599</b>		<b>776</b>		<b>1,130</b>		<b>1,130</b>		<b>177</b>	<b>30%</b>		<b>354</b>	<b>46%</b>	

<sup>2</sup>% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он**

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	16.6	25%	50.6	75%	67	26%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(36.3)		171.4		135	51%
Аж үйлдвэрлэлийн орц	65.3	82%	14.3	18%	79.6	83%
Нефтийн бүтээгдэхүүн	51.3	71%	20.8	29%	72.1	45%
Дизель түлш	39.8	73%	14.5	27%	54.3	68%
АИ-92, АИ-95	(1.4)		5.8		4.5	8%
А-80 болон бусад	12.9	96%	0.5	4%	13.4	50%
Бусад	2.0		(1.7)		0.3	14%
<b>Нийт дүн</b>	<b>99</b>	<b>28%</b>	<b>255</b>	<b>72%</b>	<b>354</b>	<b>46%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/**



2018 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 99 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 255 сая ам.доллараар өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 51 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 51%-иар өссөн нь үнийн өөрчлөлтөөс голлон шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 45%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 3 дугаар сард өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өсч тонн тутамд 679 ам.долларт хүрлээ.